



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

Сургалтын төлөвлөгөө шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг, Ерөнхий боловсролын мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2026 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 01/105 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн I, II ангийн сургалтын төлөвлөгөөг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Ерөнхий боловсролын сургуулийн I ангийн сургалтын төлөвлөгөөг 2026-2027 оны хичээлийн жилээс, II ангийн сургалтын төлөвлөгөөг 2027-2028 оны хичээлийн жилээс эхлэн дагаж мөрдөхийг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Х.Тамир), аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан Боловсролын сайдын 2026 оны "Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" А/68 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

1426010219

Боловсролын сайдын
2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн
А/62 дугаар тушаалын хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН I, II АНГИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Суралцахуйн хүрээ	Судлагдахуун	I анги								II анги	Бүгд
			I улирал				II улирал	III улирал	I анги /нийт цаг/			
			IX сар	X сар	XI сар	XII сар						
1	Монгол хэл, бичиг	Монгол хэл, унших бичиг ¹	28	28	28	14	63	63	224	224	448	
		Монгол хэл ²								96	96	
	Казах/тува хэл ²		28	28	28	14	63	63	224	160	384	
2	Математик	Математик	20	20	20	10	45	45	160	160	320	
3	Байгалийн ухаан	Байгаль шинжлэл					12	12	24	32	56	
4	Нийгмийн ухаан	Нийгмийн ухаан			8	4	18	18	48	64	112	
5	Урлаг	Хөгжим	8	8	8	4	18	18	64	64	128	
6		Дүрслэх урлаг, дизайн	8	8	8	4	18	18	64	64	128	
7	Биеийн тамир/Эрүүл мэнд		8	8	8	4	18	18	64	64	128	
			2	2	2	2	4	4	16	16	32	
8	Бүтээлч үйл ажиллагаа		12	12	8	4	9	9	54	64	118	
9	Нийгэм ахуйн баримжаа ³		Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний дагуу ³									
Сургалтын нийт цаг			86	86	90	46	205	205	718	752	1470	
Долоо хоногийн дундаж цаг			22	22	23	23	23	23	22	24		
Өдрийн дундаж цаг			4.3	4.3	4.5	4.6	4.6	4.6	4.5	4.7		

Тайлбар:

1. Ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа I-II ангид 35 минут байна.
2. Бүтээлч үйл ажиллагаа нь I-II ангид судлагдахууны суралцахуйн үр дүнг дэмжих, тоглоомд суурилсан танхимын бус сургалт, үйл ажиллагаа байна.
3. Бүтээлч үйл ажиллагааны цагийг хичээлийн цагт тооцно.
4. Эрүүл мэнд сургалтын хөтөлбөрийн зарим агуулгыг үдийн хоолны цагаар, сургалтад хамрагдсан бага ангийн багш, биеийн тамирын багш, сургуулийн хоол зүйч, эмч хамтран хэрэгжүүлнэ.

¹ Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 7.2-т заасан үндэстний цөөнхийн эх хэлээр бага ангийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулдаг ерөнхий боловсролын сургуулиас бусад ерөнхий боловсролын сургуульд судална.

² Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 7.2-т заасан үндэстний цөөнхийн эх хэлээр бага ангийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулдаг ерөнхий боловсролын сургуульд судална.

³ Боловсролын ерөнхий хуулийн 8.3, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.3-т тус тус заасны дагуу хэрэгжүүлнэ.